

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААР ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Г.Уянга**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцэн Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хороо 2015 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д заасныг баримтлан энэхүү төслийг анхны хэлэлцүүлгээр батлах горимын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Төслийн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

А.БАКЕЙ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5 дахь хэсэг нэмсүгэй:

“22.5.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 22.4-т заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг нягтлахаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага болон холбогдох бусад байгууллагаас санал, дүгнэлт авч болно. Энэ тохиолдолд тухайн байгууллага нь асуудлыг 30 хоногийн дотор судлан үзэж, санал, дүгнэлтээ ирүүлнэ.”

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах эрх, үүрэгтэй:

9.2.1.хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих;

9.2.2.хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

9.2.3.энэ хуулийн 21.1-д заасан зөвшөөрлийг олгох;

9.2.4.Төв банк, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас хөрөнгө оруулалттай холбоотой дараах мэдээллийг хагас, бүтэн жилээр гаргуулж, хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг гаргах:

9.2.4.а.хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хэмжээ;

9.2.4.б.татвар төлөлт;

9.2.4.в.ажлын байрын тоо;

9.2.4.г.гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл;

9.2.4.д.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо;

9.2.4.е.бараа, үйлчилгээний импортоор хийсэн хөрөнгийн оруулалтын хэмжээ.

9.2.5.хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

9.2.6.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;

9.2.7.хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах;

9.2.8.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх;

9.2.9.хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;

9.2.10.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтвортжуулах гэрчилгээ олгох;

9.2.11.тогтвортжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь төслийн бизнес төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл болон энэ хуулийн 16.2-т заасан хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацааны дагуу явагдаж байгаа байдалд хяналт тавих;

9.2.12.энэ хуулийн 9.2.11-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тогтвортжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн санхүүгийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, шаардлагатай тохиолдолд тухайн хуулийн этгээдээс тус тус гаргуулан авах;

9.2.13.тогтвортжуулах гэрчилгээ эзэмшигчийн улсын бүртгэл хөтлөх;

9.2.14.хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.”

3 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга” гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар эрх олгосон Засгийн газрын гишүүн” гэж, 22.5, 22.6 дахь хэсгийн дугаарыг “22.6, 22.7” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3-22.6 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг